



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 1102

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын жуулчны мэдээлэл,
сурталчилгааны төвийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг Даргын 2024 оны А/61 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг Даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.13, 7.1.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дотоод, гадаадын иргэд, жуулчдад Улаанбаатар хот болон аялал жуулчлалын бусад бүсүүдийн талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор ажиллаж байгаа жуулчны мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, шинээр үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг нээн ажиллуулсугай.

2.Улаанбаатар хотын жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах зардлыг нэгдүгээр, үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төв байгуулах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, шаардагдах 192,020,000 (нэг зуун ерэн хоёр сая хорин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын
даргын 2024 оны 01 сарын 19 өдрийн
№02 тушаалын 1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ
ТӨВ АЖИЛЛУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Цалингийн зардал	Хүн	12*6	1,350,000	97,200,000
2	Унааны зардал /Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал дахь салбар/	Сар	12*3	400,000	14,400,000
3	Түрээсийн зардал	Сар	12	1,500,000	18,000,000
4	Бичиг хэргийн зардал	Сар	12	50,000	600,000
6	Урсгал зардал /цахилгаан, ус/	Сар	12	360,000	4,320,000
7	Интернет үйлчилгээний зардал	Сар	12	90,000	1,080,000
8	Хаягжуулалт /тэмдэг тэмдэглэгээ/	Багц	1	1,750,000	1,750,000
9	Лавлах утасны зардал	Багц	1	6,500,000	6,500,000
10	Ажилчдын хувцасны зардал	Хүн	6*1	200,000	1,200,000
НИЙТ					145,050,000

5

Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын
даргын 2024 оны 01 сарын 19 өдрийн
1102 тушаалын 2 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ БҮХИЙ ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ,
СУРТАЛЧЛГААНЫ ТӨВ БАЙГУУЛАХ АЖЛЫН
ТӨСВИЙН ЗАДАРГАА

1	Принтер	1	1,600,000	1,600,000
2	Ухаалаг дэлгэц / IQ TOUCH TE1100 75"/	1	12,000,000	12,000,000
3	Ухаалаг дэлгэцийн хөл	1	600,000	600,000
4	Сандап	4	150,000	600,000
5	Ширээ	2	488,000	976,000
6	Цэвэр усны төхөөрөмж	1	430,000	430,000
7	Интернэт төхөөрөмж	1	450,000	450,000
8	Зөөврийн компьютер	1	2,300,000	2,300,000
9	Суурин утас	1	260,000	260,000
10	Кондишн	1	2,500,000	2,500,000
11	Ханын шүүгээ	1	2,660,000	2,660,000
12	Бичиг хэргийн шүүгээ	1	1,670,000	1,670,000
13	Хаяг гэрэлтүүлэг	2	2,360,000	4,720,000
14	Гэрлийн бүрхүүл, гэрэл	Багц	800 000	800,000
15	Жалюзан хөшиг	4	250,000	1,000,000
16	Сэтгүүлийн тавиур	1	1,260,000	1,260,000
17	Дугуйтай сэтгүүлийн төмөр тавиур	2	160,000	320,000
18	Хогийн сав	1	30,000	30,000
19	Хогийн сав том	1	44,000	44,000
20	Ханын цаг	1	150,000	150,000
21	Цахилгааны зардал	12 сар	450,000	5,400,000
22	Интернэт төлбөр	12 сар	60,000	720,000
23	Хог тээврийн зардал	12 сар	540,000	6,480,000
НИИТ				46,970,000